

## БНСУ-ЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА БОЛОН МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

( Цөлжилтийн асуудлаар голчлон хамтын ажиллагаа)

**Лий Дэ Хаг** магистрант (БНСУ)

- **Оршил**
- **Өрнөл**
  1. Шар шуургийн талаарх ерөнхий ойлголт
  2. Шар шуурганы асуудлыг шийдвэрлэх олон улсын хамтын ажиллагаа
  3. Шар шуургыг шийдвэрлэхийн тулд төрийн бус байгууллагын үйл ажиллагаа
  4. Шар шуурганы асуудлыг шийдвэрлэхийн тулд ажиллаж буй төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны дүгнэлт
  5. Цөлжилтийг эсрэг БНСУ болон Монголын төрийн бус байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа
- **Дүгнэлт**

**Түлхүүр үг:** Шар шуурга, цөлжилт, Монгол, Зүүн хойд Ази, БНСУ, мод тарих, төрийн бус байгууллага, хамтран ажиллах

### **Оршил**

Өнөө үед байгаль орчныг хамгаалах асуудал нь олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардаж буй асуудлын нэг юм. Байгаль орчныг ашиглах ба аж үйлдвэрийн хөгжил дэвшилын улмаас агаарын бохирдол, байгаль орчны сүйрэл, дэлхий ертөнцийн дулаарал гэх мэтийн байгалийн гамшиг нь улсын хил хязгаарыг давж өнөөгийн бүх хүн төрөлхтөний асуудал болж байна. Ойрын 10 жилд БНСУ, Зүүн азид жил бүр Монголын говиос нүүж ирсэн хүчтэй шар шуурганаас болж олон янзын хохирол гарч байна. Хүчтэй шар шуурганаас болж сургууль амарч, хичээл хаах, нисэх онгоц саатах, төрөл бүрийн амьсгалын замын өвчин ихсэх зэрэг асуудал үүсч, сэтгэл санааны болон эдийн засгийн хохирол ихээр гарч байна.

1980-иад оны үед Сөүл хотод хавар болгон нүүн ирж буй хүчтэй шар шуурганы жилийн дундаж өдөр 3,9 өдөр байсан боловч 1990 онд 7,7 өдрөөр нэмэгдсэн боловч 2001 онд 27 өдөр болж маш хурдацтай нэмэгдсэн юмаа. **1)**

Дээрх хүчтэй шар шуурганы асуудал бол ганцхан нэг улс орны асуудал биш, Зүүн хойд азийн асуудал болж байна. Одоо энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Зүүн хойд азийн улс төрийн байгууллага, төрийн бус байгууллага, пүүс компаниудын хамтын үйл ажиллагаа эхэлсэн байна.

Өгүүллэгийн бичсэн миний бие хүчтэй шар шуурганы голомт болох Монголд амьдарч байгаа учир энэ асуудлыг бодиттой үр дүн гаргахын тулд БНСУ-ын төрийн бус байгууллага болон Монголын төрийн бус байгууллага хоёр хамтран ажиллах нь нэн чухал гэдгийг ухаарч энэхүү өгүүллэгийг бичих болсон юмаа.

Ойрын хэдэн жилийн дотор Япон, БНСУ зэрэг улс оронд шар шуурганаас хамгаалах арга бол Монголд хурдастай газар авч буй цөлжилтийн асуудлыг шийдвэрлэх ёстой гэдгийг ойлгож зарим төрийн бус байгууллага болон пүүс компаниуд Монголд мод тарих ажил идэвхтэй хийж байна. Харин тэдний тарьсан мод сайн ургах тодорхой үр дүн гарахгүй байгаа нь харамсалтай үйл явдал болж байна.

Цөлжилтийг хамгаалж, хүчтэй шар шуурганаас урьдчилан сэргийлэхийн тулд Гадаадаас Монголд ирээд үйл ажиллагаа явуулж байгаа боловч Монголд энэ үйл ажиллагаа дэмжиж хамтран ажиллах байгууллага тодорхой биш учраас сайн үр дүнд хүрэхгүй байна. Энэ асуудалд тодорхой үр дүнд хүргэхийн тулд БНСУ болон Монголын төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа ямар чухал гэдгийг тус өгүүллэгээр онцлон тэмдэглэхийн хүсч байна.

- 1) Жу Гён Дү, “Зүүн хойд Азийн шар шуурганы асуудал”, БНСУ-ын байгаль орчныг хамгаалах байгууллагуудын эвсэлийн сар бүрийн сэтгүүл 2003 оны 43-р ном х.8

- **Өрнөл**

- 1. Шар шуурганы талаарх ерөнхий ойлголт**

- 1.1 Шар шуургийн талаарх тодорхойлолт**

Шар шуурга нь ази тивийн төв хэсэгт орших Хятадын баруун хойд, Монголын говь цөл, Хятад шар голын өндөр хэсэг, Өвөр монгол өөртөө засах оронд хүчтэй шуурга шуурах үед их хэмжээний тоос шороо болон элс нь агаарт өргөгдөж хүчтэй салхиар дамжиж хол газарт нүүж ирээд янз бүрийн хохиролыг гаргах явдалыг хэлнэ. **2)**

Салхийг дагасан тоос шороон агаарт өргөгдөх, нүүх, бууж унах, овоорох үе шатаар өөр өөрөөр тодорхойлдог бөгөөд хуваагддаг юмаа. Жишээ нь: Хятад бол “Элс, тоос, шороо шуурга (Dust and sand strom” гэх мэтийн олон янзаар нэрлэгдэн тодорхойлдог бөгөөд Япон бол “Өндөр агаарын (Kosa) гэж нэрлэдэг юм. БНСУ бол “Шар шуурга” гэдэг 1954 оноос улсын цаг уурын хүрээлэнд анх хэрэглэсэн юм.

Шар шороог болох газрын тоос шорооны хувийг 100% гэж бодвол ер нь 30% нь ойр орчимд унадаг, 20% нь ойрын газар нутаг дэвсгэрт унадаг, 50 % алс хол болох БНСУ, Япон, Номхон далай хүртэл явдаг. 1998 онд Номхон далайг ч гатилж Ануг хүртэл явсан юм.

## 1.2 Шар шорооны ангилал

БНУС-н улсын цаг уурын хүрээлэнгийн зарчимд шар шороог хир хол харагдаж байгааг үндэслэн 3 ангиллаар ангилдаг бөгөөд 3 цаг тусамд тогтмол ажиглаж хоорондын ялгааг бичдэг юм. 3)

Хүснэгт 1. Цаг уурын хүрээлэнгийн шар шороог ажиглах цаг

Хэр хүчтэй	Онцлог
0	Харааны багтаамж бага зэрэг шар шороотой
1	Тэнгэр нь шар шороогоор бүрхэж гадаа тарьсан юм дээр шар шороо бага зэрэг овоорох
2	Тэнгэр нь шаравтар өнгөтэй болж нарны гэрэл тод биш, шар шороо салхинд хийсэх

Тэгээд шар шорооны хэмжээгээр дараах хүснэгтийн дагуу тус хүрээлэнгээс урьдчилан мэдээлдэг юм.

Хүснэгт 2. Цаг уурын хүрээлэнгийн шар шорооны хүчийг урьдчилан мэдээлдэг зарчим

Хэр хүчтэй	Онцлог
Сул шар шороо	Шар шорооноос болж 1 цагийн дундаж микро шар шорооны хэмжээ нь 200-300 ..... орчим
Ердийн шар шороо	Шар шорооноос болж 1 цагийн дундаж микро шар шорооны хэмжээ нь 400-500 ..... орчим
Хүчтэй шар шороо	Шар шорооноос болж 1 цагийн дундаж микро шар шорооны хэмжээ нь 500.. аас дээш 1000 дээш байвал маш хүчтэй гэж нэрлэх болно.

## 1.2 Шар шороо бий болох учир шалтгаан

Зүүн хойд Азийн шар шороо нь газар зүй байдлаар Хятадын зүүн хойд хэсэг, Монголын өмнөх говь цөл хэсгийн хавьд бүрэн хуурайшилттай газар ба хагас хуурайшилттай газраас бий болдог. Ялангуяа энэ газар нутагт цөлжилт маш хурдацтай болж байгаа нь шар шороо улам ихэссэний улмаас юм.

- 2) Чү Жан Минь болон 5 эрдэмтэн “Зүүн хойд Азийн шар шуурганы хохиролыг дүгнэх ба хохиролыг багасгахын тулд хамтран ажиллах тухай 1” 2003 он, БНСУ-ын байгаль орчны төсөл, дүгнэлт хийх агентлагын тайлан, х 8

3) БНСУ-ын улсын цаг уурын хүрээлэнгийн мэдээлэл, 2002 оны 4 сарын 11

Цөлжилтийг үүсгэж буй хоёр гол хүчин зүйл нь хүний болон байгалийн нөлөөлөл байдаг. Хүний нөлөөлөл нь 87%, байгалийн хүчин зүйлсийн эзлэх хувь нь 13% орчим байдаг гэж үздэг. Хүний хүчин зүйлсд байгалийн нөөцийн зохиосгүй менежмент, ашиглалттай холбоотой үйл ажиллагаанууд болох ой, усны нөөцийн хэт ашиглалт, газрын доройтол, бэлчээр дутагдалын их сурвалж болсон мал аж ахуйн эрхлэлт зэрэг багтана. 4)

(1) Хятадын цөлжилтийн байдал

1999 он Хятадын цөлжилт болж байгаа газар нутаг нь тус нутгийн нийт газар нутгийн 29,93% буюу 267,4 мянган км<sup>2</sup> хүрсэн байна. Энэ нь БНСУ-ын нийт газар нутгийн 26,8 дахин агуу том талбай юм. 5)

Хятадад цөлжилт маш хурдацтай явагдаж байгаа газар нутаг бол газар тариалангийн аж ахуй ба мал малладаг аж ахуй хоёр нь давхцдаг байдаг газар юмаа. Дээрх газар нутгийн цөлжилтийн учир шалтгааныг авч үзвэл

1. Хүн амь олноор нэмэгдсэнээр газрыг хэт ашиглан ногоон бүс багасах болсон.
2. Мал малладаг бэлчээрийг хэт ашиглаж, ашгийн төлөө малын тоо ихээр нэмэгдсэн.
3. Орчин үеийн технологийг ашиглахгүйгээс болж газрыг зүй зохиостой ашиглаж болохгүй.

(2) Монголын цөлжилтийн байдал

НҮБ-ийн цөлжилтийн эсрэг конвенцанд Монгол бол хагас хуурайшилттай болон бүрэн хуурайшилттай газарт нутагладаг бөгөөд чийгшил маш бага нутагт оршин байдаг учраас нийт газар нутгийн 90% цөлжилтийн аюул учирч байна гэж дүгнэж байна. 6)

НҮБ-ийн хөгжлийн программ болон Монголын засгийн газар хамтран гаргасан “Монгол хүний хөгжлийн индекс” дээрх Монголд тулгамдсан өнөө үеийн асуудлыг ингэж өгүүлж байна. “Мал малладаг болон газар тариалангийн ажил эрхлэдэг хөдөөний хүмүүсийн эдийн засгийн бэрхшээл нь урт өвлийн хүйтэн цаг агаар, хур тундас багатай богино зун, хүчтэй салхи, тогтворгүй эрс тэс цаг уурын нөхцөл байдлаас болж улам хүндэрч байна”. 7) Энэ нь одоо цөлжилт явагдаж байгаа учир шалтгаан болон үүнээс болж ард түмний амьдрал хүндрэлтэй байгааг харуулж байна.

Цөлжилт нь чимээгүй мөхөл юм. Одоо Монголын нийт газар нутгийн 45% нь цөл газар бөгөөд нийт газар нутгийн 90% нь цөлжилтөнд өртөх магадлал өндөр байна. Нийт нутгийн 90% нь газар нь цөлжих аюултай бол 70% нь энэ

аюулд нэрвэгдээд байгаа бөгөөд газрын 75% нь доройтолд орж, хөрсний үржил шим нь алдагдсан юм. 8)

### 1.3 Шар шорооноос болсон хохирол

Шар шорооноос болох хохирол нь маш өргөн хүрээтэй бөгөөд маш хүнд байна.

#### (1) Их хэмжээний байгалийн гамшиг

Шар шороо бол ер хүчтэй шуургатай хамт бий болдог учраас байр байшин нурах, ой мод сүйтгэх, хүн болон мал амьтаны амь насанд аюул учирах зэрэг их хэмжээний байгалийн гамшигийг авчирдаг. 2010 оны 4 сарын 29 нд ч гэсэн ӨМӨЗО-д хүчтэй шуурга болон шар шуурганаас болж 3 хүн нас барж, их хэмжээний хохирол бий болсон юм. 9)

#### (2) Газар шорооний чанарыг сүйтгэх

Хүчтэй шуурга болон шар шороо нь газрын гадаргыг өөрчилдөг бөгөөд гадаргат шим тэжээл өгдөг бодит зүйлүүдийг устгаж их газрын чанарыг улам сүйтгэн доройтуулдаг. Үүний улмаас ямар ч ургамал ургуулах боломжгүй газар болдог.

1. Швейцарийн хөгжлийн агентлаг “www.greenmongolia.mn
2. Чү Жан Минь, дээрх ном х.13
3. Чү Жан Минь, дээрх ном х.20
4. НҮБ-ийн хөгжлийн программ болон Монголын засгийн газар хамтран гаргасан “Монгол хүний хөгжлийн индекс” 2004 он УБ, х 1
5. Швейцарийн хөгжлийн агентлаг “www.greenmongolia.mn

#### (3) Зам тээврийг саатуулах

Шар шороо нь харааны багтаамжийг багасгаж, нисэх онгоц болон машин зам тээврийг саатуулдаг.

#### (4) Эрүүл мэндийн хохирол

Шар шороо нь амьсгалын янз бүрийн өвчин, уушигний өвчин, ханиад гэх мэтийн өвчин дэлгэрэхэд нөлөөлдөг.

#### (5) Аж үйлдвэрийн хохирол

Газар тариалангийн аж ахуйг олон төрлийн жимсний модны навчит унаж, шар шорооноос болж үр жимс сайн ургуулагддаггүй болгодог. Маш цэвэрхэн байх ёстой орчин үеийн микро электрон, компьютер зэрэг аж үйлдвэрт багагүй хэмжээний хохирол учруулдаг.

#### (6) 2 дахь хохирол

Хол газар нүүж явдаг шар шороо нь нүүж явах замдаа агаарын бохир хортой бодисуудтай нийлж янз бүрийн нянг дамжуулах боломжтой. Иймэрхүү 2 дахь хохирол үүсэх магадлал өндөр болж байна гэж мэргэжилтнүүд үздэг.

## **2. Шар шуурганы асуудлыг шийдвэрлэх олон улсын хамтын ажиллагаа**

Байгаль экологийн асуудал нь олон улсын хэмжээнд хамтран ажиллахыг шаарддаг глобал асуудлын нэг мөн. Байгалийг зүй зохисгүй ашиглах болон аж үйлдвэрийн хөгжлийн улмаас агаарын бохирдол, байгаль экологийн сүйрэл бол улс орны хил хязгаарыг давсан дэлхийн бүх хүн төрөлхтний асуудал учраас энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд олон улсын хамтын ажиллагааг зайлшгүй хэрэгтэй байна. 10)

Байгаль экологийн сүйрэл бол аливаа нэгэн улс орон ба хэсэг газар нутгийн аюул биш, бүх дэлхий ертөнцөд аюул учруулдаг асуудал учраас олон улсын улс төрийн удирдлагууд хамтын ажиллагаа эрчимтэй явуулахаас аргагүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Дэлхий ертөнцийн дулаарал, ой модтой газар багасаж буй асуудал, агаар мандлын бохирдуулал гэх мэтийн байгаль экологийн асуудал нь зөвхөн улс төрийн хэмжээнд шийдвэрлэгдэх асуудал биш гэдгийг олон улс байгууллагууд болон төрийн бус байгууллагууд санал нэг байна.

Шар шуургаас урьдчилан хамгаалах олон улсын хамтын ажиллагаа бол “Олон улсын цөлжилтөөс урьдчилан хамгаалах хөтөлбөр гэрээ” байна.

### **2.1 Цөлжилтөөс урьдчилан хамгаалах хөтөлбөр**

#### **(1) Оршил<sup>11</sup>**

- Албан ёсны нэр: Маш хүнд байдлаар цөлжилт явагдаж буй Африк болон зарим улс орны цөлжилтийг урьдчилан хамгаалах гэрээ (United Convention to combat desertification in those countries experiencing serious drought and / or desertification, particularly in Africa)

Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр: 1996 оны 12 сарын 26-ны өдөр

- Гэрээнд гарын үсэг зурсан улс: 187 улс (2003 оны 8 сарын 1-ны өдрийн байдлаар)

- Гол зорилго: Цаг уурын гамшиг, ой модны сүйрэл гах мэтийн учир шалтгаанаас болсон цөлжилтийн нөлөөнд автагдсан улс орны цөлжилтийг урьдчилан хамгаалахаар дамжуулан дэлхийн байгаль экологийг хамгаалах

- 4) 2010 он 4 сарын 20-ны 21 цагийн мэдээ, БНСУ-ын KBS телевиз
- 5) Жү Сөнх Сү, Со Ён Жинь, НҮБ, Төрийн бус байгууллага, Глобал иргэний нийгэм” х, 127
- 6) БНСУ-ын Байгаль орчин яамны веб сайт, Олон улсын хамтын ажиллагааны архив, Олон улсын цөлжилтөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн веб сайт
- 7) И Сань Жинь, Олон улсын цөлжилтөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн нэгдсэн их хуралд оролцсон тайлан, БНСУ-ын байгаль орчны яамны архив

- 8) БНСУ-ын байгаль орчны яамны тайлан, х 92
- 9) Жү Сон Сү, дээрх зүйлс хуудас 128

## (2) Хөтөлбөрийн зарчим

- Цөлжилтийн урьдчилан хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Улс орон, бүс нутаг, олон улсын хэмжээний хамтын ажиллагааг бэхжүүлэх
- Байгууллага, засгийн газрын хооронд болон төрийн бус байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа

## (3) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх систем

- Холбогдох улс орны нэгдсэн их хурал: 2 жил болгон хуралдаж хөтөлбөрийг хэрэгжилт болон үйл ажиллагаа, төсвийг батладаг.
- Байнгын ажлын өрөө: Герман улсын Вонь хотод байдаг.

## (4) 6-р нэгдсэн их хурал 12)

- 2003 оны 8 сарын 25-ны өдрөөс 9 сарын 5-ны өдөр хүртэл Кова улсын Хавана хотод 170 улсын төлөөлөгчид хуралдаж оролцсон.
- 2006-2007 оны хөтөлбөрийг батласан.
- Хятад, Монгол зэрэг улс оронд цөлжилтөөс урьдчилан хамгаалахын тулд мод тарих ажил эрчимтэй өрнүүлэх хэрэгтэй гэж үзсэн юм.

## 2.2 Зүүн Хойд Азийн улс орны хамтын ажиллагаа

БНСУ, Хятад, Япон, Монгол зэрэг улс орнууд нь газар нутгийн байршилийн хувьд байгаль орчны нөлөөлөл нь адилхан байна. 1992 оноос хойш Зүүн хойд Азийн орнуудын байгаль орчны хамтын ажиллагаа хурал, дээд хэмжээний хурал, шар шуургийг урьдчилан хамгаалах үйл ажиллагаа зэрэгт хамтран ажиллах ажил бодиттой явагдаж байна.

1999 оноос БНСУ, Хятад, Япон гурван улсын байгаль орчны яамны сайдын хурал байгуулагдаж, Зүүн хойд Азийн байгаль экологийн хамтын ажиллагааны шинэ үе шат бий болсон юм. Үүнээс гадна 2003 оноос дээр 3 улсаас гадна Монгол, Орос улсыг нэмэн оруулж 5 улсын байгаль орчны яамны сайдын хурал хуралджээ. 13)

## **3. Шар шуургыг шийдвэрлэхийн тулд төрийн бус байгууллагын үйл ажиллагаа**

### 3.1 Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээ

Байгаль орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд засгийн газрын хамтын ажиллагаа бүхий л салбарт ажиллаж байгаа боловч байгаль орчны асуудлын тархалтын хурд нь улс орны хоорондын хамт ажиллагаагаар дамжуулан

асуудлыг шийдвэрлэхэд хичээн чармайж байна. Ихэндээ голдуу Олон улсын байгаль экологийн хамтын ажиллагааны гэрээнд тусган үр дүн нь урьдын ажил тодорхой бус байгаа бөгөөд хурцадмал байгаль орчны асуудлын талаар улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг шинэчилсэн ажил ч гэсэн бүтэлгүйтэж байна. Өмнө нь НҮБ-ийн орчны экологийн төслийн нарийн бичгийн дарга байсан Толба (1992)-ын заасны дагуу “Байгаль орчны асуудлын талаарх ихээхэн анхаарал татаж, санааг зовон үргэлжлүүлэн өсөж байгаа боловч бодитоор улс төрийн арга хэмжээ авч байгаа боловч урагшгүй байна. 14)

Үүнтэй адил байгаль орчны асуудлын талаар улс орны хоорондын хариу үйлдэл улс төрийн уг хэллэг болон үр дүнгүй байгаа нь хэд хэдэн шалтгаан байна. Энэ улс орон болгон улс орноо хамгаалах хандлага ба өөрийн улсын улс төр, эдийн засгийн ашгийг бодсоны улмаас асуудлыг шийдвэрлэхийн тулд улсын хамтын ажиллагаа хүндрэлтэй болдог. Байгаль орчны асуудлын хувьд дэлхий нөхцөл байдлын систем нь нэн хүндрэлтэй болж хурдтай нийлдэг болохоор нэг улсын байгалийн хохирол нь тухайн улсын хил залгаа улс орны асуудал болдог. Иймэрхүү байгаль экологийн асуудлын улс орны хил хязгаарыг давсан шинжтэй, үүний улмаас улс хоорондын хамтын үйл ажиллагааг шаарддаг боловч тухайн улс орны газар нутгийн эрх ашиг болон улсын ашгийг нэн чухалчилдаг эрх улс орны хоорондын хамтын ажиллагаа нь тийм ч амархан биш. Түүнчлэн энгийн байгаль экологийн асуудал нь улс орон болгонд шинээр захирах чадварыг шаарддаг сэдвүүд байна. Харин өнөөгийн үед эдийн засгийн чадвар нь даяарчилж байгаа хандлага улс орны аж үйлдвэрлэлийн эрх мэдэл нь илүү өргөжиж байна. Тиймээс байгалийн экологийн асуудлын талаар тэдний эдийн засгийн тал дээр улс орны захирах чадвар нь илүү суларч байна.

Шар шуургыг хамгаалахын тулд олон улсын хамтын ажиллагаа өрнүүлж байгаа боловч арайхан бодитоор үр дүнд хүрээгүй боловч шар шуургийн асуудлын төлөө Зүүн хойд Азийн орон нутагтай хамтран ажиллах нь анхан шатандаа орж байна гэж үзэхээс аргагүй. Засгийн газрын хоорондын хамтын ажиллагаа нь үргэлж өөрийн улсын эрх ашгийг нэн түрүүнд тавьсаны улмаас шар шуурганы асуудлыг шийдвэрлэхийн тулд хоёр улсын хоорондын хамтын ажиллагаанаар дамжуулан шар шуурганы асуудлыг бодиттой шийдвэрлэхийн тулд хүндрэлтэй байна гэж хэлж байна.

### 3.2 Шар шуурганы асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн бус байгууллагын үйл ажиллагаа

Шар шуурганы асуудлыг шийдвэрлэх талаар улс орны бодлого чадвар эргэлзээтэй тул төр бус байгууллагуудын нөлөө нэн чухал гэдэг байр суурь эзэлсэн. Байгаль экологийн хурцадмал асуудлыг олон улсын улс төр болон эдийн засгийн хэлэлцээрийг гол төв болгоход нэн чухал үүргийг гүйцэтгэж, НҮБ-тэй нэгдсэн байгууллагуудын үүрэг хариуцлагыг ард иргэдийн сэтгэлгээнд тулгаварлан үйлдэхээс илүүдээ системчилсэн аргыг шаардаж хэрэгжүүлсэнээр өнгөрсөн 20 жилийн турш хурдацтай өргөжиж ирсэн. 15)



### (1) Япон “Японы цөлжилтийн эсрэг мод тарих холбоо”

Цөлжилт хамгаалалт ба холбоотой Хятад болон Японы иргэдийн байгууллагууд нь шар шуургыг хамгаалахын тулд ажиллаж буй олон улсын хамтын ажиллагаанд хамгийн идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд олон жил ажилласан. Цөлжилтийг хамгаалахын тулд ажилладаг Японы тэргүүн төрийн бус байгууллага бол “Японы цөлжилт эсрэг мод тарих холбоо” байна. 1991 онд Япон Тодори их сургуулийн Тояама багш тус байгууллагыг байгуулсаны дараа өнөөг хүртэл Хятадын Күбүчи цөлд мод тарих ажил ням үргэлжүүлэн хийсээр ирсэн. 1999 он хүртэл 2 сая 140 мянган ширхэг мод тарьсан бөгөөд 2000 онд 301 удаа мод тарих үйл ажиллагааг зохион байгуулаад 5.877 хүн оролцсон юм. 16)

Япон цөлжилтийн эсрэг мод тарих холбооны үйл ажиллагааны онцлог

1. Мод тарих үйл ажиллагааг явуулдаг газарт ажлын төв байгуулж амьдардаг юм. Тэгээд тарьсан модыг хамгаалах үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, тодорхой үр дүнд хүргэдэг.
2. “Ногоон байгууламжын төлөөх хамтран ажиллах баг” бүрдүүлж пүүс компани, сургууль, үйлдвэрчдийн эвсэл, улс төрийн намууд, иргэний хөдөлгөөн зэргээс сайн дурын оролцогчдыг элсүүлж үйл ажиллагааг чанаржуулан өргөн хүрээтэй ажиллаж байна.
3. Хятадын байгууллага, компани, сургууль, иргэний байгууллагуудтай хамтран ажиллагаа явуулдаг төдийгүй хоёр улсын хоорондын харилцаа нөхөрлөлийг бий болгодог.
4. Олон төрлийн хичээл семинар, соёлын арга хэмжээ, аялал жуулчлалын хөтөлбөрийг зохион байгуулж, цөлжилт явагдаж буй газар нутагт амьдардаг нутгийн ард иргэдтэй сайн харилцаа тогтоож зөвхөн мод тарих ажил биш, боловсрол ба соёлын арга хэмжээ болгон хэрэгжүүлж байна.

### ( 2 ) БНСУ-ын “Зүүн хойд Азийн ой мод форум” 17)

Тус форум нь Зүүн хойд азийн улс орны хоорондын хамтын ажиллах сүлжээг бэхжүүлж, байгаль орчныг хамгаалах ба зүй зохистой ашиглах зорилгоор 1998 онд байгуулагдсан юм. Байгуулагдсаны дараа Хятадын Милүн гэдэг газар нутаг дэвсгэрт “Хятад–БНСУ-ын найрамдалын ой”-г зохион байгуулж цөлжилтийг хамгаалах олон улсын хамтын ажиллагаанд зүтгэж байна. Тэгээд Хятад, Монгол, БНАСУ, Орос зэрэг улс оронтой хамтран ажиллах хүрээгээ өрнүүлж байна.

2007 онд 2 удаа олон улсын хэмжээний хурал семинарыг зохион байгуулсан, Хятад ба Монголд мод тарих ажлыг явуулсан бөгөөд НҮБ болон олон улсын байгууллагатай хамтарсан юм.

15. Ким Дун Чүнээс гадна 5 хүн “Төрийн бус байгууллага гэж юу вэ?, Арике, 2000, Сөүл, х,74

16. Чү Жань Минь, дээрх ном, хуудас 63

17. Тус байгууллагын веб сайт

(3 Дээрх дурдсан байгууллагаас гадна Япон, БНСУ-т маш олон цөлжилтийг хамгаалах тал дээр ажиллаж буй төрийн бус байгууллагууд болон компани байдаг.

Ойрын хэдэн жилүүдэд БНСУ-ын олон улсын Ротари клуб, Корейн Аир компани жил болгон Монголд мод тарих ажилд идэвхтэй оролцож байна.

#### **4. Шар шуурганы асуудлыг шийдвэрлэхийн тулд ажиллаж буй төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны дүгнэлт**

Байгаль орчныг хамгаалах асуудал бол зөвхөн улс бүрийн засгийн газрын хүч, хичээл зүтгэл, улс хоорондын хамтын ажиллагаагаар шийдвэрлэж чадахгүй болно. Цөлжилтийг урьдчилан хамгаалахын тулд улс орон бүрийн засгийн газрын хичээл зүтгэл, хоёр тал болон олон талын хамтын ажиллагаа, НҮБ ба олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, төрийн бус байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа зэрэг бүх талаас нь хамтран ажиллахыг шаардаж байна.

Шар шуургыг урьдчилан хамгаалах ба цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд улс бүрийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, эвсэл нэгдэх ажил хэрэгтэй байна. Өнөөдөр Зүүн хойд Азийн улс орны төрийн бус байгууллагууд нэгдэж хамтран ажиллах цаг аль хэдийн ирчихээд байна.

Хамтын ажиллагааг хүчтэй явуулахын тулд өнөөгийн цөлжилтийн эсрэг төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг дүгнэж үзэх хэрэгтэй.

4.1 Анхан үе шаттай байна.

Цөлжилтийн эсрэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа нь анхан үе шаттай явагдаж байна гэж хэлж болно. Өнөөдөр цөлжилтийн аюулыг тодорхойлох ойлголтыг ухаарч энэ асуудлаар судалгаа явуулж, хэрэгжүүлэх ажлуудыг хийж байна. Ер нь цөлжилтийн эсрэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа нь 2000 оноос өрнөсөн болохоор өнөөгийн байдлаар цөлжилтийн эсрэг эрчимтэй хамтын ажиллагаа хүчирхэгжихгүй байна. Цөлжилтийн эсрэг төрийн бус байгууллагуудын ажил бол дөнгөж эхлэж байна гэж хэлж болно. Цөлжилтийн эсрэг үйл ажиллагаа нь зөвхөн мод тарих ажил биш маш олон талаас авч үзэх ёстой үйл ажиллагаа юм.

4.2 Төрийн бус байгууллагуудын оролцоо бага байна.

Шар шуурга, цөлжилт ямар аюултай гэдгийг ойлгосон боловч энэ асуудлын төлөө ажиллаж буй төрийн бус байгууллагууд цөөхөн байна. 2000 онд БНСУ-ын төрийн бус байгууллагуудын нэгдсэн санд 4,023 төрийн сан байгууллага бүртгүүлснээс байгаль орчноо хамгаалах үйл ажиллагаанд

оролцдог төрийн бус байгууллага нь 7.1 хувь буюу 287 төрийн бус байгууллага байна. 18)

2000 оноос хойш маш олон төрийн бус байгууллагууд байгуулагдсан боловч цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд оролцдог төрийн бус байгууллагууд бол маш цөөхөн байна.

#### 4.3 Нэг удаагийн үйл ажиллагаа болж байна.

Цөлжилтийн эсрэг ажиллаж буй төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа нь удаан хугацаагаар үргэлжлэх үйл ажиллагаанаас илүү нэг удаагийн сурталчилгаа маягын үйл ажиллагаа болж байна. Монголын нөхцөл байдлыг сайн ойлгохгүй, тарьсан мод сайн ургуулахад шаардлагатай ажилд анхаарал тавихгүй байна. Олон хүний нүдэнд харагдаж буй газар дээр мод тарьж, үнэхээр мод тарих ёстой газарт одоохондоо ямар ч үйл ажиллагаа явуулахгүй байна.

#### 4.4 Зорилго нь тодорхой биш байна.

Өнөөдөр Монголд ирээд цөлжилтийн эсрэг мод тарьдаг зарим нэг төрийн бус байгууллагууд нь мод тарихаар ирсэн үү, өөрийнхөө байгууллагыг сурталчилахаар ирсэн үү эсвэл аялал жуулчлалаар ирсэн үү гэдэг нь ойлгомжгүй байна. Цөлжилтийн эсрэг үйл ажиллагааны төлөө Монголд ирсэн төрийн бус байгууллагуудын хөтөлбөрөөс авч үзвэл зорилго нь тодорхой биш тал байна.

#### 4.5 Монголын төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа байхгүй байна.

Цөлжилтийн эсрэг үйл ажиллагааны төлөө Монголд ирсэн ихэнх гадаадын төрийн бус байгууллагууд нь орон нутгийн засаг захиргаатай хамтран ажилладаг болохоор сайн үр дүнд хүрэхгүй байна. Монголын төрийн бус байгууллагуудтай бараг хамтран ажилладаггүй байна. Төрийн бус байгууллагуудыг дэмжиж, зүй зохиостой үйл ажиллагаа явуулахын тулд хяналт тавих үүрэгтэй байгууллага болон төрийн бус байгууллага юм.

#### 4.6 Нэг талаас бүхийг шийдэж байна.

Цөлжилтийн эсрэг үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэхэд Монголын нөхцөл байдлыг сайн ойлгох хэрэгтэй. Тусалцаа дэмжлэг үзүүлж буй талаар бүхнийг шийдэж тусалцаа авах тал бол зүгээр авах нэг талын харилцаа биш, хоёр талын харилцаатай байх ёстой. Монгол ба гадаадын төрийн бус байгууллагууд нь тал талаас нь бие биенээ хүндэтгэж, нөхцөл байдлыг зөв ойлгон хамтрах хэрэгтэй байна.

## **5. Цөлжилтийн эсрэг БНСУ болон Монголын төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа**

БНСУ-д төрийн бус байгууллаг маш хөгжсөн гэж үзэж болно. Төрийн бус байгууллага бол улс төрийн байгууллага болон зах зээлийн дараа гурав дахь хүчин болж нийгэмд маш үүрэг гүйцэтгэж байна. Тиймээс учраас БНСУ-т өнөө үеийг” Иргэний хөдөлгөөний үе” гэж хэлж болно. 19) Зарим төрийн бус байгууллагын гишүүдийн тоо хэдэн зуу мянган болсон бөгөөд жилийн төсөл нь тэрбум воныг давсан байна.

Тэгвэл өнөөдөр Монголын төрийн бус байгууллагууд хувьд ямар байна вэ?

2002 онд 3000 орчим төрийн бус байгууллага бүртгэгдэж байсан бол 20) 2009 онд 7000 болж нэмэгдсэн байна. Харин 7000 гаруй төрийн бус байгууллагуудын дотроос 10 хувь нь идэвхтэй үйл ажиллагааг явуулдаг 80 хувь орчим нь хүүхэд болон нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст тусламж үзүүлдэг тусламжын байгууллага, 500 гаруй байгууллага бол ямар үйл ажиллагааг явуулж байгаа ч тодорхой биш байна. 21)

Өнөөдөр Монголын төрийн бус байгууллагууд бол тийм ч сайн хөгжөөгүй боловч БНСУ-ын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой. БНСУ-ын төрийн бус байгууллагууд цөлжилтийн эсрэг үйл ажиллагаа явуулахыг хүсч байгаа бол Монголын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ёстой. БНСУ-д ч одооноос 20 жилийн өмнө төрийн бус байгууллагууд сайн хөгжихгүй байна. Монголын төрийн бус байгууллагууд ч одоо хөгжлийн үе явцанд байгаа учраас БНСУ-ын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, туршлага хувааж, дэмжих хэрэгтэй байна. Энэ нь глобалчлалын үеийн олон улсын хамтран ажиллах дүрэм зарчимтай.

БНСУ болон Монголын төрийн бус байгууллага хэрхэн хамтран ажиллах вэ?

### **5.1 Харилцаа холбоог тогтоож мэдээлэлийг солилцох**

БНСУ-ын төрийн бус байгууллагууд нь Монголын төрийн бус байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, мэдээ мэдээлэлийг солилцох хэрэгтэй. Ялангуяа ижил төстэй зорилготой, үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хоорондын харилцаа тогтоовол үр дүнд хүрэх боломжтой. Өнөө үед бол заавал биеэрээ уулзах биш, цахилгаан мэдээлэлээр дамжуулан онлайн-аар холбоо барьж ч болно. Найрсаг, хамтран ажиллах харилцаа холбоог тогтоож байнга мэдээ мэдээлэлийг солилцох бөгөөд хэрэгтэй үед шууд холбоо барих сүлжээ хэрэгтэй.

### **5.2 Хамтарсан хурал семинар зохион байгуулах**

Монголын төрийн бус байгууллагууд бодиттой хөгжиж, өөрсдийн нийгмийн асуудлуудыг зөв ойлгож, асуудлаа шийдвэрлэх чадвартай болгохын тулд хурал семинарыг зохион байгуулж бие биеэс суралцах хэрэгтэй. Хурал

семинарыг зохион байгуулах үед адил тэгш эрх мэдэлтэй байх хэрэгтэй бөгөөд хоёр талаас нь оролцох боломжтой байх ёстой.

### 5.3 Хамтран үйл ажиллагааг зохион байгуулах

Монгол болон БНСУ-ын төрийн бус байгууллагуудын хамтран цөлжилтийн эсрэг арга хэмжээ зохион байгуулах болно. Хоёр улсын төрийн бус байгууллагуудын гишүүд хамтран ажиллах үед хоёр улсын найрсаг харилцаа нь улам хөгжиж, үйл ажиллагааны үр дүн ч маш сайн байх болно. Жишээлбэл цөлжилтийн эсрэг мод тарих ажил хамтран зохион байгуулвал хамтран мод тариад Монголын төрийн бус байгууллагууд тарьсан модыг сайн ургуулж хамгаалах болно.

### 5.4 Олон улсын хуралд хамт оролцох

Зөвхөн хоёр улсын төрийн бус байгууллагууд хамтран ажиллах бус, олон улсын хэмжээний хурал семинарт хамтран оролцож үйл ажиллагаагаа танилцуулж, улам өргөн хүрээтэй ажиллах боломжтой.

### 5.5 Боловсон хүчин бэлтгэх

Төрийн бус байгууллагыг хөгжихын тулд төрийн бус байгууллагын талаарх мэргэшсэн сайн боловсон хүчин хэрэгтэй байна. БНСУ-д олон их дээд сургуульд төрийн бус байгууллагын танхим байдаг. Сөүл хотын Гён Хи их сургууль, Сөнгонхой их сургууль зэрэг төрийн бус байгууллагын талаар бакалбар, магистрант, доктрант зэрэг цол хамгаалах болно.

18. Жу Хи Ёнь, “БНСУын төрийн бус байгууллагуудын түүх, өнөөгийн байдал ба ирээдүй” х, 140

19. Ха Сөн Чань, “Төрийн бус байгууллагын тухай яриа” х. 22

20. Монголын төрийн бус байгууллагийн эмхтгэл ном

21. Өнөөдөр сонин 2009 оны 2 сарын 10-ны өдрийн 1,3 нүүр

22. И Сан Жин “Цөлжилтийн эсрэг сэргийлэх хамтын ажиллагааны гэрээний 2 дугаарт заасан Азийн төлөөлөгчдын хурлын үр дүн” Байгаль орчны яам олон улсын харилцааны веб сайт

## Дүгнэлт

Хятад, Монголын цөлжилт ба шар шуурганы асуудал нь Зүүн хойд Азийн хамгийн чухал байгаль экологийн тулгамдсан асуудал нь гэж үзэж байна.

Шар шуурганы улмаас Зүүн хойд Азийн улс орнууд эдийн засаг, нийгмийн тал дээр хохирол амсаж байгаа бөгөөд шар шуурганы асуудал нь хурдастай илэрч байна. Өнөөгийн үед нэн тулгамдсан асуудал болж цөлжилт ба шар

шуурганаас урьдчилан сэргийлэхийн тулд бодиттой арга хэмжээ авахгүй бол болохгүй нээ гэсэн нөхцөл байдалтай тулгарч байна. Шар шуурганы асуудал нэг улсын асуудал биш Зүүн хойд Азийн асуудал болж, цөлжилт ба шар шуурганаас урьдчилан сэргийлэхийн тулд улс орон бүр хооронд, оролцогч бүрийн хооронд олон талын хэлэлцээ ба хамтын ажиллагаа бий болж, үүний төлөө олон улсын хамтын үйл ажиллагааг ч гэсэн эрчимтэй бий болж байна. Тухайн улсын нөөц баялагаас нь биш НҮБ ба олон улсын байгууллага, улс орны төрийн бус байгууллагууд ч гэсэн асуудалд нухацтай хандаж бодиттой үйл ажиллагаа өрнүүлж байна. Шар шуургыг урьдчилан сэргийлэхийн тулд Төрийн бус байгууллагын хүчин чадварыг аажим аажимаар чухалчилж байна. Яагаад гэвэл шар шуурганы асуудалтай холбоотой Зүүн хойд Азийн улс орон дундаас Солонгосын төрийн бус байгууллагууд энэ асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр болж байгаа нь шар шуурганы улмаас хамгийн түрүүнд хохирч байгаа улс юм.

Зүүн хойд Азийн улс орнууд дундаас Япон шууд хохирогч биш учраас санаачлага муутай байдаг бөгөөд Хятадад төрийн бус байгууллага байхгүй гэж хэлэх ч буруутахгүй харин Монголд одооноос төрийн бус байгууллага бий болж байгаа боловч одоохондоо үйл ажиллагааны чадвар болон туршлага сул байна. Солонгосын төрийн бус байгууллагууд шар шуурганы асуудалд анхааралаа хандуулж, цөлжилт ба шар шуурганаас урьдчилан сэргийлэхийн тулд засгийн газруудын хооронд, төрийн бус байгууллага, олон улсын орноо хамгаалах үйл ажиллагаанд нэгдэн эвсэхийг зохион байгуулах хэрэгтэй гэж чухалчилж байна.

Үүний тулд Солонгосын төрийн бус байгууллагууд Хятад, Монголын засгийн газартай хамтран ажиллаад зогсохгүй, ардчилсаны дараа иргэний нийгэм бүрэлдэн тогтож байгаа Монголын төрийн бус байгууллагууд идэвхтэй санаачлагатайгаар туслаж нэгдэн эвсэн, хамтран ажиллах хэрэгтэй. Хөгжсөн улс орны байр суурины үүднээс биш харилцагчаа хүндэтгэн, хөхүүлэн дэмжих байр сууринаас Солонгосын төрийн бус байгууллагууд Монголын төрийн бус байгууллагуудда тусалсанаар сайн хамтрагчдыг бий болгож чадна.

2003 оны 6 сард Аравын Миритын Абата дүүрэгт болсон цөлжилтийн эсрэг гэсэн нэг зорилготойгоор хамтрагчдыг хөхүүлэн дэмжиж, ард иргэдийн нийгмийн оролцоог идэвхтэй санаачилгатайгаар оролцуулах хэрэгтэй гэсэн үр дүнд хүрсэн. Солонгос–онголын төрийн бус байгууллагууд хамтран санаачилгатайгаар тусалвал цөлжилт ба шар шуурганаас урьдчилан сэргийлэх зорилгот нэгдэхээс гадна төрийн бус байгууллагууд өөрсдийн шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх болно.

### **Хавсралт: Ашигласан ном болон материал**

1. Байгаль орчины яам “2004 он Байгаль орчин” 2004, Сөүл
2. Чү Жаны Минь гадна 5 хүн “Зүүн хойд Азийн шар шуурганы хохирлын ангилал болон хохиролыг багасгах хамтын ажиллагааны арга хэмжээ” Солонгосын байгаль орчин бодлого, дүгнэлт судалгааны ажилтан, 2003, Сөүл

3. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Монголын улс төр, “2003 он Монгол хүний хөгжлийн индекс” 2004, Монгол Улаан баатар
4. Жү Сонь Сү, Со Ёнь Жиний хамтран бүтээл “НҮБ, Төрийн бус байгууллага, Глобал иргэний нийгэм”, Ханян Их Сургуулийн хэвлэлийн газар 2000, сэтгүүл
5. Ким Дун Чүн гадна 5 хүн “Төрийн бус байгууллага гэж юу вэ?” Арик, 2000, Сөүл
6. Ха Сын Чан “Төрийн бус байгууллагын талаарх ярилцлага” Түүхийн сүлжээ, 2001, Сөүл
7. Монголын төрийн бус байгууллагын эмхтгэл 2003, Улаанбаатар
8. Жу Гён Дү “Зүүн хойд Азийн шар шуурганы асуудал”, Байгаль орчныг хамгаалах иргэний байгууллагуудын холбооны сэтгүүл 2003 он 43-р дугаар
9. Жу ХИ Ёнь “БНСУ-ын төрийн бус байгууллагуудын түүх, өнөөгийн байдал ба ирээдүй” Арик , 2000, Сөүл
10. БНСУ-ын байгаль орчины яамны вэб сайт [www.me.go.kr](http://www.me.go.kr)
11. Зүүн хойд Азийн ой модны форем вэб сайт [www.neaff.org](http://www.neaff.org)
12. Швейцарийн хөгжлийн агентлаг вэб сайт [www.greenmongolia.mn](http://www.greenmongolia.mn)

### **Abstract**

The yellow sand problem that is from desertization is the problems of northeast Asia and whole world. Mongolia is the country that fastly desertizing and being a root of the yellowsand. Currently, there are many anti desertizing movements like planting the trees; however, it could not show explicit result yet. To make these movements to result much more, not only the government, but also Mongolian citizen and non-government organizations (NGO) should participate together. Moreover, when Korean NGOs help and cooperate together with Mongolian NGOs, anti desertization can be more activated.